



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН  
ТУШААЛ

2012 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А-134

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.11.3, 4.17.6, Ректорын зөвлөлийн 2012 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн оюутнуудад кредитийн урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар баталж, 2012 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Батлагдсан журмыг мөрдөж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг СБЗГ /Н.Ганзориг/, ЗХШҮГ /Ж.Арслан/, бүрэлдэхүүн сургуулийн захирлуудад даалгасугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Ректорын 2003 оны 65 тоот тушаалаар баталсан “Урлаг соёлын арга хэмжээнд оролцсон оюутнуудыг шагнаж урамшуулах журам”, 2004 оны 127 тоот тушаалаар баталсан “ШУТИС-ийн оюутны байгууллагын тэргүүлэгчдэд тэтгэлэг олгох журам”, “Биеийн тамир, спортын сургалтыг зохион байгуулах журам”-ын 3 дугаар бүлэг, 2004 оны 262 тоот тушаалаар баталсан “Ректорын нэрэмжит тэтгэлэгт хамруулах журам”-ын 1.2, 3.2, 4.2, 2009 оны 253 тоот тушаалаар баталсан “Шилдэг оюутан шалгаруулах журам”-ын 3.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

РЕКТОР



Б. ДАМДИНСҮРЭН